



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/145-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Дорнод аймаг 2020 он</p>	<p>Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: М.Ухаанбилэг Утас: 70584207 Цахим хаяг: Ukhaanbilegm@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
БХС	Байгаль хамгаалах сан



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.12. Шилэн дансны мэдээлэл.....	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Менежментийн захидал	10
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	12
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	123
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	144
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	155
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	176
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	187





**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.27 № 139

танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

2020.02.27 №139 D: Mv computer – TOOT A4

110520139



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ





2.1. Оршил

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Г.Цэцэгсүрэн танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 15-наас 2020 оны 02 дугаар сарын 21-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 27-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 25 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.



2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Гурванзагал сумын ЗДТГ нь “Төрийн үйлчилгээг сум орон нутгийн иргэдэд түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй хүргэх” гэсэн эрхэм зорилгын хүрээнд ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Гурванзагал сумын ЗДТГ нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд АСОЛУОС программ хангамж ашигладаг байна.

Гурванзагал сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Гурванзагал сумын ЗДТГ-ын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 15 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 307,241.4 мянган төгрөгөөс тооцон 6,144.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 6,910.4 мянган төгрөгөөр тогтоож өмнөх оноос өссөн нь тайлант онд санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25,538.9 мянган төгрөгөөр өссөн байна. Материаллаг хэмжээний өөрчлөлт орсон хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/



Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	297.3	0.0	-297.3
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	97,348.4	96,145.5	-1,202.9
Үндсэн хөрөнгө	870,365.7	945,019.4	74,653.7
Элэгдэл	-211,499.9	-259,114.3	-47,614.4
Нийт хөрөнгө	756,511.7	782,050.6	25,538.9
Өр төлбөр	2,797.8	2,797.8	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	753,713.8	779,252.7	25,538.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	756,511.7	782,050.6	25,538.9

Бараа материалын дансны үлдэгдэл өмнө оноос буурсан нь өмнө оны сэлбэг хэрэгслийн материалын үлдэгдлийг зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь хөрөнгө оруулалтаас шалтгаалжээ. Сумын ОНХС-аас 25,216.6 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж, Улсын төсвийн хөрөнгөөр 18,772.8 мянган төгрөгийн гүний худаг, Байгал хамгаалах сангаас 14,780.0 мянган төгрөгийн худаг, төмөр хашааны дүнгээр нэмэгдсэн байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэлд өөрчлөлт ороогүй нь өмнө оны өглөгийн үлдэгдлийг барагдуулж ажиллаагүйтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо өссөн нь хөрөнгө оруулалтаар үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Туслах үйл ажиллагааны орлого	1,000.0	1,000.0	0.0	100
Нийт дүн	1,000.0	1,000.0	0.0	100

Гурванзагал сумын ЗДТГ нь орлогын батлагдсан төлөвлөгөөг бүрэн биелүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 288,865.7 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 287,865.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 288,865.7 мянган төгрөг буюу 100.0 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.



Нэмэлт төсөв: Хүнс, хөдөө, аж ахуйн газраас 11,820.0 мянган төгрөгийг оготно устгалд, Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газраас 300.0 мянган төгрөгийг сумын ард иргэдээс гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой судалгааг авахад, аймгийн ЗДТГ-аас түймрийн зардалд 1,684.2 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс мал тооллогын зардалд 316.1 мянган төгрөг, байгаль хамгаалах сангаас шатахууны зардалд 425,5 мянган төгрөг, байгууллагын туслах үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 3,908.1 мянган төгрөг нийт 18,454.0 мянган төгрөгийн нэмэлт төсөв бүрдүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн орлогоос 298,8 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд, 4,825.0 мянган төгрөгийг тээвэр шатахууны зардалд, 1,136.9 мянган төгрөгийг түймрийн хүнсний зардалд, 1,860.9 мянган төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 3,250.0 мянган төгрөгийг багаж техник хэрэгсэлд, 1,206.2 мянган төгрөгийг албан томилолтын зардалд, 5,876.0 мянган төгрөгийг /оготно устгал/ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд тус тус зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 15 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 15 эрсдэл тодорхойлж нийт 15 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 37,945.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 31,867.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,253.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 3,824.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 31,867.5 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 2,253.2 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Тайлант хугацаанд хийсэн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад бүрэн хавсаргаагүй, татварын ебаримт программд 28,719.2 мянган төгрөгийн худалдан авалт бүртгэгдээгүй нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3.1.3 дахь “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-тай тус тус нийцэхгүй, үнэн зөв байдал, тохиолдсон байх, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.*

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Сумын Засаг даргын захирамжаар нийт 3,148,300.0 төгрөгийг тухайн шатны төсөвт хамаарах ч урьдчилан төлөвлөх боломжтой, нэг удаагийн бус шинж чанартай арга хэмжээнд зарцуулсан нь *Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам”-ын 2.2.1 дэх “урьдчилан тооцох боломжтой, жил бүр давтагддаг дараах зардал, арга хэмжээ”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

3. Сумын Засаг даргын захирамжаар нийт 870,0 мянган төгрөгийг журамд заагдаагүй, тухайн шатны төсөвт хамаарахгүй арга хэмжээнд зарцуулсан, Түлш халаалтын хэмнэлтээс 1,383.2 сая төгрөгийн нүүрс бэлтгэж он дамжуулан зарцуулсан нь *Сангийн Сайдын 2018 оны 318 дугаар “Засаг даргын нөөцийн*



хөрөнгийн зориулалт, зарцуулалтын журам"-ын Засаг даргын санхүүжүүлэхээр заасан дараах арга хэмжээнд тусгаагдаагүй зардал санхүүжүүлсэн байна., Төсвийн тухай 43.5 дахь заалт "Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3, 43.1.5-д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй." гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох.

Аудитаар илэрсэн 3,824.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Гурванзагал сумын ЗДТГ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллүүдээс хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББ-ийн тухай хуулийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын **агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс** урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Бараа материалын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

ЗДТГ-ын 1999 оны Лексус470 маркийн автомашин нь ЗГ-ын 2015 оны 184 дүгээр тогтоолоор батлагдсан нормоос хэтрүүлэн 1,086.7 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан тохиолдол илэрсэн.

1.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үргүй зарцуулагдах

1.3. Өгсөн зөвлөмж:

2020 оны 1 дүгээр сард актлагдсан тул ЗГ-ын 2018 оны 184 дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөв.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

2. Өглөгийн данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Өмнө аудитаар өглөгөөр тусгуулсан 2,797.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна.

2.2. Эрсдэл:

Төсвийн хөрөнгийн эргэц удаашрах

2.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж ажиллах

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:



Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>97,645,905.51</u>	<u>96,145,560.51</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	297,513.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	297,513.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	97,348,392.51	95,675,560.51
351	Түүхий эд материал	1,692,620.00	1,964,000.00
35110	Тусгай зориулалттай материал	1,692,620.00	1,964,000.00
354	Хангамжийн материал	31,575,822.51	24,711,560.51
35410	Бичиг хэргийн материал	512,700.00	476,200.00
35420	Аж ахуйн материал	20,825,260.00	17,039,755.00
35430	Сэлбэг хэрэгсэл	4,940,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	855,056.51	2,793,799.51
35470	Бусад хангамжийн материал	4,442,806.00	4,401,806.00
35600	Мал амьтад	64,079,950.00	69,000,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА	-	470,000.00
36300	Тэжээлийн нөөц	-	470,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>658,865,806.99</u>	<u>685,905,122.21</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	658,865,806.99	685,905,122.21
392	Биет хөрөнгө	638,453,806.99	664,822,678.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	370,100,273.21	370,100,273.21
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,205,553.44)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63,135,705.00	63,135,705.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(18,842,994.50)	(37,362,282.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	88,236,333.00	113,788,333.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(40,415,110.80)	(42,277,115.82)



39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	31,535,651.77	34,185,651.77
39208	Хуримтлагдсан элэгдэл	(14,501,615.24)	(16,487,099.51)
39209	Зам, гүүрийн байгууламж	6,140,461.10	6,140,461.10
39210	Хуримтлагдсан элэгдэл	(3,270,725.80)	(3,577,748.80)
39214	Бусад үндсэн хөрөнгө	289,334,740.00	334,854,223.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(132,998,910.75)	(149,472,168.53)
393	Биет бус хөрөнгө	20,412,000.00	21,082,443.31
39301	Програм хангамж	1,582,600.00	2,514,800.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(970,600.00)	(1,232,356.69)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,300,000.00	20,300,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(500,000.00)	(500,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>756,511,712.50</u>	<u>782,050,682.72</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>2,797,854.00</u>	<u>2,797,854.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,797,854.00	2,797,854.00
413	Өглөг	2,797,854.00	2,797,854.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	2,797,854.00	2,797,854.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>733,913,858.50</u>	<u>779,252,828.72</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	733,913,858.50	779,252,828.72
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	337,198,534.17	356,998,534.17
51101	Өмч: - төрийн	337,198,534.17	356,998,534.17
512	Хуримтлагдсан үр дүн	151,086,936.61	176,625,906.83
51210	Өмнөх үеийн үр дүн	144,061,928.01	151,086,936.61
51220	Тайлант үеийн үр дүн	7,025,008.60	25,538,970.22
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	245,628,387.72	245,628,387.72
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>736,711,712.50</u>	<u>782,050,682.72</u>



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	314266460.00	371059189.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32765000.00	356364858.00
120	Нийтлэг татварын бус орлого	32765000.00	68499158.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32765000.00	68499158.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4759300.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0.00	375.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32765000.00	63739483.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	287865700.00
123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	0.00	287865700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	281501460.00	14694331.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	27518300.00	0.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	27518300.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17179660.00	14694331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8369786.00	14301281.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8809874.00	393050.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236803500.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236803500.00	0.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	307241451.40	345520218.78
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297723451.40	345520218.78
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295491170.80	342108218.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	173041738.00	176632113.00
210101	Үндсэн цалин	173041738.00	176632113.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20474103.00	22502100.00
210201	Тэтгэврийн даатгал	13509403.00	15006200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1463600.00	1863800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1617200.00	1490700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352900.00	373200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3531000.00	3768200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9848718.89	14920164.00
210301	Гэрэл, цахилгаан	2096662.00	2867861.00
210302	Түлш, халаалт	7752056.89	11880903.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	171400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19962172.00	43321182.00
210401	Бичиг хэрэг	1762010.00	5519478.00
210402	Тээвэр, шатахуун	10067662.00	23069079.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6066000.00	4783600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2066500.00	9949025.00
2105	Нормативт зардал	0.00	1586900.00



Гурванзагал сумын ЗДТГ-ын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210502	Хоол, хүнс	0.00	1136900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0.00	450000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2644600.00	8213800.00
210604	Урсгал засвар	2644600.00	8213800.00
2107	Томилолт, зочны зардал	2725500.00	9292760.00
210702	Дотоод албан томилолт	2725500.00	9292760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294720.00	7149957.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5876040.00
210803	Даатгалын үйлчилгээ	283720.00	608917.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11000.00	300000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	350000.00
210807	Газрын төлбөр	0.00	15000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	66499618.91	58489242.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23057830.00	10874875.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	43441788.91	47614367.78
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2232280.60	3412000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	3412000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	3412000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2232280.60	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2232280.60	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	9518000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	9518000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	9518000.00	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7025008.60	25538970.22
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	0.00	0.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7025008.60	25538970.22

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	281501460.00	307319706.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	0.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	292625375.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	4759675.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	0.00	4759675.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	4759300.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	0.00	375.00
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.00	287865700.00



123003	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг	0.00	287865700.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	281501460.00	14694331.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	27518300.00	0.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	27518300.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	17179660.00	14694331.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8369786.00	14301281.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	8809874.00	393050.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	236803500.00	0.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	236803500.00	0.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	253983460.00	307319706.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	253983460.00	307319706.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251751179.40	303907706.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	171453900.00	176334600.00
210101	Үндсэн цалин	171453900.00	176334600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19561600.00	22502100.00
210201	Тэтгэврийн даатгал	12596900.00	15006200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1463600.00	1863800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1617200.00	1490700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	352900.00	373200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3531000.00	3768200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	9999999.40	14725000.00
210301	Гэрэл, цахилгаан	2096662.00	2867861.00
210302	Түлш, халаалт	7903337.40	11685739.00
210303	Цэвэр, бохир ус	0.00	171400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21297630.00	34147474.00
210401	Бичиг хэрэг	1790300.00	5481478.00
210402	Тээвэр, шатахуун	10026730.00	19436996.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6090000.00	4903600.00
210404	Ном, хэвлэл	0.00	78500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3390600.00	4246900.00
2105	Нормативт зардал	300000.00	2586900.00
210502	Хоол, хүнс	0.00	1136900.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300000.00	1450000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3000000.00	11793800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	8250000.00
210604	Урсгал засвар	3000000.00	3543800.00
2107	Томилолт, зочны зардал	2725500.00	9292760.00
210702	Дотоод албан томилолт	2725500.00	9292760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	294720.00	14664157.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	5876040.00
210803	Даатгалын үйлчилгээ	283720.00	608917.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	11000.00	300000.00



210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	350000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	7514200.00
210807	Газрын төлбөр	0.00	15000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23117830.00	17860915.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	23117830.00	17860915.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2232280.60	3412000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	0.00	3412000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	3412000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2232280.60	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2232280.60	0.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	27518000.00	0.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	27518000.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	27518000.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	27518000.00	0.00
223001	Бусад хөрөнгө	27518000.00	0.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-27518000.00	0.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	0.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	0.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,998,534.17	245,628,387.72	151,086,936.61	753,713,858.50
2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	356,998,534.17	245,628,387.72	151,086,936.61	753,713,858.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,998,534.17	245,628,387.72	151,086,936.61	753,713,858.50
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00	0.00



Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	25,538,970.22	25,538,970.22
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	356,998,534.17	245,628,387.72	176,625,906.83	779,252,828.72

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	288865700.00	288865700.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288865700.00	288865700.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	285453700.00	285453700.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	176334600.00	176334600.00
210101	Үндсэн цалин	176334600.00	176334600.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22502100.00	22502100.00
210201	Тэтгэврийн даатгал	15048300.00	15006200.00
210202	Тэтгэмжийн даатгал	1863800.00	1863800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1490700.00	1490700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	373200.00	373200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3726100.00	3768200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14725000.00	14725000.00
210301	Гэрэл, цахилгаан	3000000.00	2867861.00
210302	Түлш, халаалт	11500000.00	11685739.00
210303	Цэвэр, бохир ус	225000.00	171400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29067300.00	29023583.00
210401	Бичиг хэрэг	5244300.00	5182603.00
210402	Тээвэр, шатахуун	14061100.00	14611980.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4765000.00	4903600.00
210404	Ном, хэвлэл	250000.00	78500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4746900.00	4246900.00
2105	Нормативт зардал	1450000.00	1450000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1450000.00	1450000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8500000.00	8543800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5000000.00	5000000.00
210604	Урсгал засвар	3500000.00	3543800.00
2107	Томилолт, зочны зардал	8086500.00	8086500.00
210702	Дотоод албан томилолт	8086500.00	8086500.00



2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8788200.00	8788117.00
210803	Даатгалын үйлчилгээ	609000.00	608917.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300000.00	300000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	350000.00	350000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	7514200.00	7514200.00
210807	Газрын төлбөр	15000.00	15000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16000000.00	16000000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16000000.00	16000000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3412000.00	3412000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3412000.00	3412000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3412000.00	3412000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00